



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/41

Батширээт сум

Дайчлагдах хүн хүч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшиг осол гарсан тохиолдолд дайчлах хүн хүчийг 01 дүгээр хавсралтаар, техник хэрэглэлийг 02 дугаар хавсралтаар, нүүлгэн шилжүүлэх газрыг 03 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтад заасан нэр бүхий иргэд дайчилгаанд хамрагдах багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийг үүрэг гүйцэтгэх бэлэн байлгаж, өөрийн бичиг баримт, хүнс, хувцас хэрэглэлийг бэлтгэн дайчилгаа зарласан газарт тогтоосон хугацаанд ирүүлэхийг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501001